



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 1/339

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн Эрүүл мэндийн
төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 159,400,000.0 /нэг зуун тавин есөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв /З.Балдандугар/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй нийт 159,400,000.0 /нэг зуун тавин есөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв /З.Балдандугар/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /С.Ариунжаргал/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

D:\Tushaal 2019\Tushaal-1\9 cap.docx

115050001031

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 09 сарын 24 өдрийн А/389 дугаар тушаалын хавсралт



Хөрөнгө данснаас хасах тухай санал

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв

| Д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|--|-------------------------------------|---------------|-------------|------------|---------------|----------------------|----------------------|--------------|-----------------|--------------------------|
| 1 | Рентген аппарат ГУ системтэй TU51с/ | 8 | ш | 1 | 159,400,000.0 | 159,400,000.0 | 159,400,000.0 | - | хугацаа дууссан | татах |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | 159,400,000.0 | 159,400,000.0 | - | | |
| Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | |
| Акглах хөрөнгө | | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | 159,400,000.0 | 159,400,000.0 | 0.0 | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | |
| НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/ | | | | | | | | | | |